



ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦАХИЛГААН
ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ ХК

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО

2024 он

НЭГ. БОДЛОГЫН ЗОРИЛГО

- 1.1 Мэдээллийн аюулгүй байдлын бодлого нь Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Байгууллага нууцын тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Мэдээллийн аюулгүй байдлын ISO/IEC 27001:2022 стандартад нийцсэн байна.
- 1.2 Мэдээллийн аюулгүй байдлыг олон улсын стандартын түвшинд хэрэгжүүлж мэдээллийн хөрөнгө, түүний нууцлал халдашгүй байдал, бүрэн бүтэн, хүртээмжтэй байдлыг ханган техник, технологийн дэвшлийг ашиглан тасралтгүй сайжруулж, хууль эрх зүйг дээдлэн ажиллана.
- 1.3 Мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг өөрчлөх эсэх талаар удирдлагууд жилдээ нэг удаа хянана.

ХОЁР. ЗОРИЛТ

- 2.1 Монгол улсын хууль, зохицуулагч байгууллагын мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой дүрэм, журам, стандартын шаардлагыг хангаж ажиллана.
- 2.2 Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг тогтмол хийж, эрсдэлийг бууруулж ажиллана.
- 2.3 Хэрэглэгч болон гуравдагч талуудтайгаа гэрээ байгуулж, хамтарч ажиллахдаа мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал болон хүртээмжтэй байдлыг хангаж ажиллана.
- 2.4 Мэдээллийн аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг үр дүнтэй байлгахын тулд компанийн бүх ажилтан болон гуравдагч байгууллага, хэрэглэгчдэд мэдээллийн аюулгүй байдлыг тасралтгүй сайжруулахаар мэдээлэл зөвлөмж өгч ажиллана.
- 2.5 Мэдээллийн хөрөнгө нь компанийн өмч бөгөөд бүрэн бүтэн байдал болон нууцлалыг чанд хамгаална.
- 2.6 Хэрэглэгч болон хамтрагч байгууллагын хүлээлт, итгэлцэл, сэтгэл ханамжийг дээшлүүлэхийн тулд Мэдээллийн аюулгүй байдлын менежментийн тогтолцооны аудитыг тогтмол хугацаанд хийлгэж бүтээгдэхүүн үйлчилгээ, систем, дэд бүтцийн хэвийн тасралтгүй найдвартай ажиллагааг хангаж ажиллана.